



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/196

Пионер толгой

Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны хөрөнгө оруулалтад тусгагдсан нохой устгалын ажилд хяналт тавих, хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 10/02 тоот тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны хөрөнгө оруулалтад тусгагдсан нохой устгалын ажлыг О.Эрдэнэбатаар гүйцэтгүүлсүгэй.

2. Нохой устгалын ажилд хяналт тавих, хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Ш.Нархүү	Байгаль орчны хяналтын Улсын байцаагч
Гишүүд:	Ч.Батцэцэг	Пионер толгой 5 дугаар багийн Засаг дарга
	Л.Дуламдорж	Хэсгийн төлөөлөгч
	М.Бат-Эрдэнэ	Байгаль хамгаалагч
	Б.Рэнцэндагва	Хот тохижилтын авто машины жолооч
	З.Ганбаатар	Хот тохижилтын ажилтан

3. Нохой устгалын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, хамтарч ажиллахыг ажлын хэсэг (Ш.Нархүү)-т даалгасугай.

ДАРГА



Б.ГАНТУЛГА

2023/Засаг дарга/Захирамж/2023

612201421